

**БАТЛАВ:**  
СУРГАЛТ, ОЮУТНЫ ХӨГЖИЛ ЭРХЭЛСЭН  
ПРОРЕКТОР *Д.Заяабаатар* Д.ЗАЯАБААТАР

**2025-2026 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН МУИС-ИЙН ОЮУТНЫ УРЛАГИЙН ИХ  
НААДМЫН УДИРДАМЖ**

**Зорилго:** Ардын уламжлалт болон орчин үеийн урлагаар дамжуулан оюутан залууст эерэг соёлыг түгээх мөн МУИС-ийн соёл оюутан хоорондын харилцааг бэхжүүлэх, гоо зүйн мэдлэгийг дээшлүүлэх, амралт чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, шинэ уран бүтээлч залуусыг уран бүтээл туурвихад дэмжлэг үзүүлэх, МУИС-ийн урлагийн авьяастай оюутан залуучуудыг шалгаруулж МУИС-ийн оюутны нэгдсэн урлагийн тоглолт зохион байгуулах:

**Үр дүн, ач холбогдол:**

1. МУИС-ийн оюутны урлагийн баг, хамтлагуудыг бэлтгэх
2. Суралцагчдын урлаг, гоо зүйн боловсролыг дээшлүүлэх
3. Багш, ажилчид, суралцагчдад зориулсан үнэ төлбөргүй урлагийн их наадам шилдэг үзүүлбэрүүдээс бүрдсэн тоглолт зохион байгуулах
4. Нийгмийн хариуцлагын хүрээнд урлагийн их наадмын шилдэг үзүүлбэрүүдээс бүрдсэн тоглолт зохион байгуулах

**Хамрах хүрээ:** МУИС-ийн бакалаврын түвшний оюутнууд

**Хугацаа:** 2026 оны 04 дүгээр сарын 18-ны 09:00 цагт

**Хаана:** Улаанбаатар театр

**Зохион байгуулагч:** МУИС-ийн Оюутны хөгжлийн газар, МУИСОХ

**Урлагийн их наадмын хөтөлбөр:**

№	Хөтөлбөр		Огноо	Цаг
1	Хөтлөгч наадмыг эхлүүлнэ	МУИС-ийн урлагийн их наадмыг эхлүүлэх	2026.04.18	09:00
2	Мэндчилгээ	Бүх салбар сургууль		
3	Гоцлол дуу	Бүх салбар сургууль		09:10
4	Хамтлаг бүжиг /Цэнгээнт/	Бүх салбар сургууль		10:30
5	Завсарлага	Цайны завсарлага		12:50
6	Нээлт	Сургалт, оюутны хөгжил эрхэлсэн проректор Д.Заяабаатар үг хэлнэ, МУИС-ийн захиргаа, бүрэлдэхүүн сургуулийн захирал нар оролцоно		13:00
7	Гоцлол эсвэл хоршил хөгжим	Бүх салбар сургууль		13:20
8	Ардын болон язгуур урлаг	Бүх салбар сургууль		14:40
9	Хамтлаг бүжиг чөлөөт	Бүх салбар сургууль		15:20
10	Шагнал гардуулах ёслол	Үзүүлбэр тус бүрээр шагналт байруудыг шагнах, шилдэг сургуулийг шалгаруулна		16:40
11	Хаалт	Хаалтын үг, урлагийн их наадамд оролцогчид зураг даруулна		17:00

Урлагийн наадам нь нийт 6 төрлөөр явагдана. Үүнд:

- **Мэндчилгээ /3-5 минут сэдэв: *Бидний өнгө-МУИС* /**
- 1. **Ардын болон язгуур урлаг /3-5 минут хөөмий, исгэрээ, бие биелгээ, магтаал, тууль гэх мэт язгуур үзүүлбэрүүд байх багууд 10-с илүүгүй оролцогчтой байх/**
- 2. **Гоцлол дуу /3-5 минут сонгодог, эстрад, бусад/**
- 3. **Цэнгээнт бүжиг: /5 минутаас ихгүй байх, 8 хос 16 гишүүнтэй байх/**
- 4. **Гоцлол, хоршил хөгжим: /3-5 минут/**
- 5. **Чөлөөт бүжиг /4-6 минут, багийн нийт гишүүд 16-аас илүүгүй оролцогчтой байна./**

### **Шалгуур үзүүлэлт:**

- Ур чадвар
- Бэлтгэл, бичлэг болон хөгжмийн зэмсэг, ая шаардлага хангасан байдал
- Тайзны соёл, хувцаслалт
- Бэлтгэл зохион байгуулалт, найруулга агуулга сайн байх


### **Тавигдах шаардлага:**

- МУИС-ийн оюутан байх
- Салбар сургуулийн “Оюутны зөвлөл”-дөө оролцох төрөл үзүүлбэрээ урьдчилан мэдэгдэж бүртгүүлсэн байх
- Удирдамж заасан дагуу хугацаа, ая, хөгжим, хувцас тайзны жижиг хэрэгсэл бусад бэлтгэлээ урьдчилан хангасан байх
- Үзүүлбэр тодорхой, ойлгомжтой тоглолтын ерөнхий зохиомжид нийцсэн байх
- Урлагийн тоглолт үзүүлбэрийн үед шүүгчид, бусад оролцогчид, хамт олноо хүндэтгэн оролцох
- Үзүүлбэр эхлэхээс өмнө багийн бэлтгэлийг хангаж байраа эзэлсэн байх
- Багууд мэдүүлгийнхээ дагуу оролцох
- Шүүгчид, зохион байгуулагчдын гаргасан шийдвэр үнэлгээг хүлээн зөвшөөрч соёлтой оролцох
- Баг тус бүр өөрийн багийн оролцогч гишүүд болон багийн нийт гишүүдийн нэрс, үзүүлбэрийн нэрийг урьдчилан мэдүүлсэн мэдүүлгийг 2026 оны 04 сарын 10-нд 16:00 цагт Багш оюутны хөгжлийн төвийн 3 давхар 306 тоотод ирүүлсэн байх
- Багийн мэдүүлэг урьдчилан ирүүлээгүй баг хамт олны багийн нийлбэр онооноос 2 бүхэл оноо хасна

## Дүгнэх, шалгаруулах журам:

- Урлагийн наадмыг мэргэжлийн шүүгчид дүгнэж шалгаруулна
- Оноог нийтэд ил тод нээлттэй өргөж танилцуулах бөгөөд шүүгч тус бүр 1-10 онооны нарийвчлалаар дүгнэнэ
- Үзүүлбэр тус бүрд тайзны соёл, хувцаслалт баг хамт олны зохион байгуулалт зэргийг харгалзан үзэж дүгнэнэ
- Үзүүлбэр тус бүрийг заасан хугацаанд явагдаж байгаа эсэхэд хяналт тавих хөндлөнгийн шүүгч ажиллах бөгөөд хугацаа хэтэрсэн тохиолдолд 0,5 оноог үзүүлбэрээс хасаж дүгнэх
- Мэндчилгээний төрөлд 1 байр шалгаруулж өргөмжлөл гардуулна
- Үзүүлбэр тус бүр 1, 2, 3 дугаар байр шалгаруулж өргөмжлөл гардуулна
- Шилдэг багаар 1, 2, 3 дугаар байрт шалгаруулж өргөмжлөл мөнгөн шагнал гардуулна

Боловсруулсан:



Оюутны хөгжлийн төвийн мэргэжилтэн

А.Пагамсүрэн

Хянасан:



Оюутны хөгжлийн газрын ахлах мэргэжилтэн

Л.Чинзориг



Оюутны хөгжлийн газрын дарга

Б.Цэцэнцолмон